



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/151

Улаанбаатар хот

Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.2.2, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, зохион байгуулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	М.Долгион (Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газрын мэргэжилтэн)
Гишүүд:	М.Энхжаргал (Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн)
	Б.Батжаргал (Эрүүл мэндийн технологи инновацийн хамтын ажиллагааны хүрээлэн НҮТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн төрийн бус) (зөвшилцсөнөөр)
	Т.Отгонтөгс (Сэтгэлд мөнхөрсөн үйлс төрийн бус байгууллагын зохицуулагч) (зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга:	Ж.Халиунаа (Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн газрын мэргэжилтэн)

1422 010151

2.Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (М.Долгион)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хороонд ажиллах албан хаагчдын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл, тайлбарыг"-ыг холбогдох маягтын дагуу гаргуулан байгууллагын (ЭБАТ)-д бүртгүүлж, худалдан авах ажиллагаатай холбогдох бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга (Ж.Халиунаа)-д даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгсэлийн хяналт зохицуулалтын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/89 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.НАРАНТУЯА